



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/386

Булган сум

“Нийгмийн эрүүл мэндийг дэмжих” сэдэвт  
үйл ажиллагааг зохион байгуулахад  
хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II/04 дүгээр тогтоолоор батлагдсан “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.1.2.4 дэх заалт, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг батлах тухай” захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний” хуулийг иргэд, албан байгууллагад таниулан сурталчлах зорилгоор зохион байгуулах “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих” сэдэвт нөлөөллийн үйл ажиллагааны удирдамжийг 1 дүгээр, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Үйл ажиллагааг зохион байгуулахад шаардлагатай 394,000 (гурван зуун ерөн дөрвөн мянга) төгрөгийг “Эрүүл мэнд” хөтөлбөр арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2024 оны  
05 дугаар сарын 21-ний өдрийн 1286 дугаар  
захирамжийн 1 дүгээр хавсралт



**“НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ” СӨДЭВТ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ**

**Нэг. Үндэслэл:**

“Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол улсын Их хурлын 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн чуулганаар “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай” анхдагч хууль батлагдсан.

Тус хуулийг иргэд болон төрийн албан хаагчдад таниулан сурталчлахаар 2024 онд эрүүл мэндийн салбарт “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарлаад байна.

Иргэдэд эрүүл мэндийн мэдлэг олгох, цаашлаад эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх нөлөөллийн арга хэмжээг “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих” сэдвээр зохион байгуулж, иргэд, байгууллага, аж ахуй нэгжийн албан хаагчдын оролцоог нэмэгдүүлэх нь чухал юм.

**Хоёр. Зорилго:**

Иргэдэд эрүүл, зөв амьдралын хэв маягийг төлөвшүүлэх замаар сэргийлж болох халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх ая холбогдлын талаар сурталчлан таниулах

**Гурав. Зохион байгуулах үйл ажиллагааны чиглэл:**

- Ахмадын хорооноос дасгал, шугаман бүжиг заах
- Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүд эрүүл амьдралын жор, зөвлөгөө, мэдээлэл өгөх
- Нэгдсэн эмнэлгийн эмч, мэргэжилтнүүд өвчний хүндрэл, эрсдэлийг бууруулах зөвлөгөө өгөх
- Эм холбооны эм зүйч, эм найруулагчид эмийн зохистой хэрэглээний талаарх зөвлөгөө, мэдээлэл өгөх
- Эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүд шүдний зөв арчилгаа, эрт илрүүлгийн ач холбогдлыг сурталчлах
- Биеийн тамир спортын газрын мэргэжилтэн, арга зүйч нар эрүүл мэндийн дасгалыг заах, биометрик шинжилгээ, хэмжилт хийх

**Дөрөв. Хамрах хүрээ:**

Булган сумын иргэд, төрийн болон төрийн бус байгууллага

**Тав. Зохион байгуулагдах газар:** Цогт хунтайжийн талбай

**Зургаа. Хугацаа:** 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 10 цагт

**Долоо. Хүлээгдэж буй үр дүн:**

Хүн амд эрүүл, зөв амьдралын хэв маягтай холбоотой эрсдэл, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээллээр хангаж, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан байна.

Аймгийн Засаг даргын 2024 оны  
05 дугаар сарын 17-ны/ний өдрийн А/386 дугаар  
захирамжийн 2 дугаар хавсралт

**АЖЛЫН БАЙРНЫ ДАДЛАГА СУРГАЛТЫН ТӨСӨВ**

| д/д | Шаардагдах зардал  | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэг бүрийн үнэ | Нийт           |
|-----|--------------------|-------------|------------|----------------|----------------|
| 1   | 2                  | 3           | 4          | 5              | 6              |
| 1   | Хөөсөн хэвлэл      | Ширхэг      | 8          | 28000          | 224,000        |
|     | Бичиг хэргийн багц | Ширхэг      | 5          | 34000          | 170,000        |
|     | Дүн                |             |            |                | <b>394,000</b> |